ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Дундговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДУА-2026/119/НА-СТА-ТШЗ**


Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439
Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Батсайхан
Утас: 70592225
Цахим хаяг: batsaikhant@audit.gov.mn

Аудитор: Л.Баянмөнх
Утас: 99997540
Цахим хаяг: bayanmunkhamina@gmail.com



Цахим хуудас: www.audit.mn

Дундговь аймаг

2026 он


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# Агуулга

**1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ...... 2**

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ...... 4**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ...... 4**

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ...... 5**

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ...... 6**

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ...... 8**

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ...... 9**

**3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ...... 10**

**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ...... 16**

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2026.02.28 № 47

танай ______ -ны № ______ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН
НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Н.ЦЭРЭНДУЛАМ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад өр төлбөрийн дансны үлдэгдэл өмнөх оноос 712.1 сая төгрөгөөр өссөн нь өмнөх оноос эмийн үнэ болон хэрэглээ нэмэгдсэн, Эрүүл мэндийн даатгалын хэлтсээс архаг өвчлөлийн тусламж үйлчилгээнд хязгаарлал тогтоосноос гүйцэтгэлийн санхүүжилтийг бүрэн авч чадаагүйтэй холбоотой байна. Мөн өмнөх онд шинэ барилгыг хүлээн авч бүртгэлд тайланд тусгасантай холбоотой тайлант оны үнэ төлбөргүй хүлээн авсан орлого (Үндсэн хөрөнгө) 12,071.5 сая төгрөгөөр буурчээ. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж,

4826050259

аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 15 зорилт, 97 арга хэмжээг тусгаж хэрэгжилтийг хангаж ажилласнаар Эрүүл мэндийн газрын даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 91.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Р.МӨНХТОГТОХ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| ДАНС | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | **617,447,186.20** | **636,180,488.60** |
| 31 | МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ | 44,824,149.55 | 17,772,385.40 |
| 312 | Банканд байгаа бэлэн мөнгө | 44,824,149.55 | 17,772,385.40 |
| 3121 | Төгрөг | 44,824,149.55 | 17,772,385.40 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 27,912,328.55 | 17,772,385.40 |
| 31214 | Бусад төсөл нөөцийн харилцах | 16,911,821.00 | - |
| 33 | АВЛАГА | **6,114,511.00** | **8,806,942.49** |
| 33100 | Ажиллагсадтай холбогдсон авлага | - | 1,091,321.00 |
| 33300 | Татаас санхүүжилтийн авлага | - | 6,175,821.00 |
| 335 | Бусад авлага | 6,114,511.00 | 1,539,800.49 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 826,500.00 | 1,539,800.49 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 5,288,011.00 | - |
| 34 | УРЬДЧИЛГАА | - | 9,790,000.00 |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | - | 9,790,000.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | **566,508,525.65** | **599,811,160.71** |
| 351 | Түүхий эд материал | 259,915,778.13 | 250,327,418.49 |
| 35130 | Эм боох материал | 259,915,778.13 | 250,327,418.49 |
| 354 | Хангамжийн материал | 306,592,747.52 | 349,483,742.22 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,583,912.00 | 30,332,138.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 288,369,542.12 | 310,423,921.12 |
| 35440 | Түлш шатах тослох материал | 908,200.00 | - |
| 35450 | Барилгын засварын материал | 2,710,900.00 | 572,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 6,454,545.70 | 5,075,851.90 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 5,565,647.70 | 3,079,831.20 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | **23,105,804,695.69** | **22,607,961,574.81** |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | **23,105,804,695.69** | **22,607,961,574.81** |
| 392 | Биет хөрөнгө | **22,928,418,195.69** | **22,430,755,574.85** |
| 39201 | Барилга, байгууламж | 13,019,484,219.28 | 13,019,484,219.28 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (736,663,213.78) | (1,065,178,673.84) |
| 39203 | Авто тээврийн хэрэгсэл | 1,934,606,978.20 | 1,934,606,978.20 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (342,943,908.98) | (690,616,059.08) |
| 39205 | Машин, тоног төхөөрөмж | 11,460,414,150.30 | 13,442,540,268.26 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (3,039,652,510.69) | (4,728,137,465.88) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 845,936,266.88 | 923,077,066.88 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (212,763,785.52) | (405,020,758.97) |
| 393 | Биет бус хөрөнгө | 177,386,500.00 | 177,205,999.96 |
| 39301 | Программ хангамж | 902,500.00 | 902,500.00 |
| 39302 | Хасагдуулаг | - | (180,500.04) |
| 39305 | Газар эзэмших эрх | **176,484,000.00** | **176,484,000.00** |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **23,723,251,881.89** | **23,244,142,063.41** |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН | **2,028,649,344.95** | **2,740,700,085.03** |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | **2,028,649,344.95** | **2,740,700,085.03** |
| 413 | Өглөг | 1,644,530,051.85 | 2,446,368,718.19 |

| | | | |
|---|---|---|---|
| 41310 | Ажиллагчидтай холбогдсон өглөг | 426,066,218.41 | 766,992,089.45 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 1,213,907,811.44 | 1,674,547,773.74 |
| 4136 | Бусад өглөг | 4,556,022.00 | 4,828,855.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 3,891,919.00 | 3,928,419.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 664,103.00 | 900,436.00 |
| 414 | Урьдчилж орсон орлого | 384,119,293.10 | 294,331,366.84 |
| 41420 | Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого | 384,119,293.10 | 294,331,366.84 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 21,694,602,536.94 | 20,503,441,978.38 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 21,694,602,536.94 | 20,503,441,978.38 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан | 2,778,419,201.46 | 2,778,419,201.46 |
| 51101 | Өмч: -Төрийн өмч | 2,778,419,201.46 | 2,778,419,201.46 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 17,151,849,456.79 | 15,960,688,898.23 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 17,151,849,456.79 | 17,151,849,456.79 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (1,191,160,558.56) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,764,333,878.69 | 1,764,333,878.69 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН** | **23,723,251,881.89** | **23,244,142,063.41** |

## 2.2 **Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

/төгрөгөөр/

| ДАНС | ҮЗҮҮЛЭЛТ | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 25,689,546,212.84 | 13,618,019,480.61 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 15,437,476,692.34 | 2,997,379,879.61 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 15,437,476,692.34 | 2,997,379,879.61 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 526,563,689.00 | 712,851,479.57 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 384,027,689.00 | 323,824,496.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 142,536,000.00 | 389,026,983.57 |
| 1200017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-үндсэн хөрөнгө | 14,828,165,614.94 | 2,055,661,917.96 |
| 1200018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-бараа материал | 82,747,388.40 | 228,866,482.08 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 10,252,069,520.50 | 10,620,639,601.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 861,886,000.00 | 1,129,909,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 861,886,000.00 | 1,129,909,000.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс | 9,390,183,520.50 | 9,490,730,601.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас | 9,390,183,520.50 | 9,490,730,601.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II) | 12,934,029,909.38 | 14,809,180,039.17 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 12,934,029,909.38 | 14,809,180,039.17 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 12,813,888,909.38 | 14,283,300,163.60 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 7,030,832,525.67 | 7,364,442,292.00 |
| 210101 | Цалин | 3,486,927,426.47 | 3,734,347,196.76 |
| 210102 | Нэмэгдэл цалин | 3,189,805,369.20 | 3,023,281,931.30 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 189,363,805.00 | 227,873,655.00 |
| 210104 | Урамшуулал | 164,735,925.00 | 378,939,508.94 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 882,587,900.55 | 907,881,344.71 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 637,304,340.68 | 641,524,757.58 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 61,744,000.00 | 76,060,902.44 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 30,872,000.09 | 40,204,430.65 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 30,872,000.00 | 33,808,246.12 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 121,795,559.78 | 116,283,007.92 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 782,593,296.24 | 738,931,065.16 |

| | | | |
|---|---|---|---|
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 100,131,095.84 | 124,129,472.50 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 600,231,418.40 | 526,528,006.00 |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 82,230,782.00 | 88,273,586.66 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 141,338,217.94 | 212,841,859.62 |
| 210401 | Бичиг хэргийн материал | 12,545,618.00 | 69,152,564.00 |
| 210402 | Тээвэр, шатахууны зардал | 69,706,330.00 | 79,899,277.12 |
| 210403 | Шуудан холбоо интернетийн төлбөр | 9,092,389.24 | 7,059,431.00 |
| 210405 | Хог хаягдал устгах, цэвэрлэх | 38,619,854.00 | 40,336,306.50 |
| 210406 | Бага үнэ түргэн элэгдэл зүйлс | 165,000.00 | - |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 11,209,026.70 | 16,394,281.00 |
| 2105 | Нормативт зардал | 2,215,410,421.34 | 2,371,381,590.27 |
| 210501 | Эм | 2,000,824,789.14 | 2,108,788,204.67 |
| 210502 | Хоол | 214,513,032.20 | 262,494,905.60 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 72,600.00 | 98,480.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 46,093,050.00 | 60,098,379.00 |
| 210604 | Урсгал засвар | 46,093,050.00 | 60,098,379.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 13,309,880.00 | 14,984,000.00 |
| 210702 | Дотоод томилолтын зардал | 13,309,880.00 | 14,984,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 35,942,390.00 | 44,893,594.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,735,400.00 | 11,703,275.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 2,044,000.00 | 2,280,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээний төлбөр | 1,000,000.00 | 5,000,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 4,654,440.00 | 688,532.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 286,500.00 | 209,000.00 |
| 210806 | Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс | 13,364,800.00 | 20,139,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,312,940.00 | 1,142,918.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягтын зардал | 6,544,310.00 | 3,730,869.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,665,781,227.64 | 2,567,846,038.84 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,925,100.00 | 10,736,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 1,655,856,127.64 | 2,557,110,038.84 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 120,141,000.00 | 525,879,875.57 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 120,141,000.00 | 371,276,156.57 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 700,000.00 | 306,640,156.57 |
| 213208 | Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 112,536,000.00 | 63,336,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 6,905,000.00 | 1,300,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 154,603,719.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 154,603,719.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II) | 12,755,516,303.46 | (1,191,160,558.56) |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V) | 525,248.81 | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 525,248.81 | - |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V) | (525,248.81) | - |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI) | 12,754,991,054.65 | (1,191,160,558.56) |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| ДАНС | Үзүүлэлт | ГҮЙЦЭТГЭЛ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **11,356,271,999.20** | **11,248,991,165.31** |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 544,467,689.00 | 718,139,490.57 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 544,467,689.00 | 718,139,490.57 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 544,467,689.00 | 718,139,490.57 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 386,931,689.00 | 323,824,496.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 157,536,000.00 | 394,314,994.57 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **10,811,804,310.20** | **10,530,851,674.74** |

| | | | |
|---|---|---|---|
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 861,886,000.00 | 1,129,909,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 861,886,000.00 | 1,129,909,000.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 9,949,918,310.20 | 9,400,942,674.74 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 9,949,918,310.20 | 9,400,942,674.74 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)** | **11,340,848,556.55** | **11,272,437,929.46** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **11,340,848,556.55** | **11,272,437,929.46** |
| **210** | **БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **11,211,600,545.55** | **10,740,382,232.89** |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 7,170,326,917.12 | 7,042,200,090.44 |
| 210101 | Үндсэн цалин | 3,539,008,402.74 | 3,412,104,995.20 |
| 210102 | Нэмэгдэл | 3,153,566,496.38 | 3,023,281,931.30 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 184,875,115.00 | 227,873,655.00 |
| 210104 | Үр дүнгийн урамшуулал | 292,876,903.00 | 378,939,508.94 |
| 2102 | Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл | 950,246,679.43 | 890,729,463.72 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 704,951,130.65 | 624,372,876.79 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 61,744,000.00 | 76,060,902.44 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 30,872,000.00 | 40,204,430.65 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 30,883,989.00 | 33,808,246.12 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 121,795,559.78 | 116,283,007.72 |
| 2103 | Байр ашиглалтай  холбоотой тогтмол зардал | 861,886,000.00 | 924,026,922.00 |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 94,607,872.18 | 124,129,472.50 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 676,471,417.82 | 711,623,862.84 |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 90,806,710.00 | 88,273,586.66 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 152,931,099.24 | 127,287,085.12 |
| 210401 | Бичиг хэрэг | 14,208,390.00 | 11,786,670.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 74,754,270.00 | 72,233,314.12 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 9,092,389.24 | 7,070,431.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 27,973,220.00 | 11,431,820.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 26,902,830.00 | 24,764,850.00 |
| 2105 | Нормативт зардал | 1,975,478,739.76 | 1,616,965,777.61 |
| 210501 | Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,738,469,603.76 | 1,435,547,499.81 |
| 210502 | Хоол, хүнс | 230,127,456.00 | 173,628,277.80 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 6,881,680.00 | 7,790,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 45,290,200.00 | 70,532,389.00 |
| 210601 | Багаж техник хэрэгсэл | - | 7,612,250.00 |
| 210602 | Тавилга | - | 910,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллийн хэрэгсэл | - | 1,970,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 45,290,200.00 | 60,040,139.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 11,937,880.00 | 11,893,280.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 11,937,880.00 | 11,893,280.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 33,577,930.00 | 46,011,225.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 6,735,400.00 | 11,703,275.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,044,000.00 | 2,280,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,000,000.00 | 5,000,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 4,654,440.00 | 688,532.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 286,500.00 | 209,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 13,364,800.00 | 20,139,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,312,940.00 | 1,142,918.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 4,179,850.00 | 4,848,500.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,925,100.00 | 10,736,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,925,100.00 | 10,736,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **129,248,011.00** | **532,055,696.57** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 129,248,011.00 | 371,276,156.57 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 5,988,011.00 | - |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 306,640,156.57 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогвортой ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 115,440,000.00 | 63,336,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 7,820,000.00 | 1,300,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 160,779,540.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 160,779,540.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **15,423,442.65** | **(23,446,764.15)** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **114,266,700.00** | **3,605,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **114,266,700.00** | **3,605,000.00** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 114,266,700.00 | 3,605,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 114,266,700.00 | 3,605,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(114,266,700.00)** | **(3,605,000.00)** |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **(98,843,257.35)** | **(27,051,764.15)** |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 143,667,406.90 | 44,824,149.55 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 44,824,149.55 | 17,772,385.40 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| КОД | ҮЗҮҮЛЭЛТ | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2024 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл | 2,778,419,201.46 | 1,765,220,329.35 | 4,395,971,951.48 | 8,939,611,482.29 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 886,450.66 | 886,450.66 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,778,419,201.46 | 1,765,220,329.35 | 4,396,858,402.14 | 8,940,497,932.95 |
| C07 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | - | - | 12,754,991,054.65 | 12,754,991,054.65 |
| C08 | 2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 2,778,419,201.46 | 1,764,333,878.69 | 17,151,849,456.79 | 21,694,602,536.94 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| D01 | 2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 2,778,419,201.46 | 1,764,333,878.69 | 17,151,849,456.79 | 21,694,602,536.94 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,778,419,201.46 | 1,764,333,878.69 | 17,151,849,456.79 | 21,694,602,536.94 |
| D08 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | - | - | -1,191,160,558.56 | -1,191,160,558.56 |
| D09 | 2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 2,778,419,201.46 | 1,764,333,878.69 | 15,960,688,898.23 | 20,503,441,978.38 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| ДАНС | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 44,824,149.55 |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 11,921,916,528.55 | 11,276,042,929.46 |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 11,921,916,528.55 | 11,276,042,929.46 |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | 11,472,874,928.55 | 10,743,987,232.89 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 7,431,302,600.00 | 7,042,200,090.44 |
| 210101 | Үндсэн цалин | 3,768,091,500.00 | 3,412,104,995.20 |
| 210102 | Нэмэгдэл | 2,742,194,400.00 | 3,023,281,931.30 |
| 210103 | Унаа, болон бусад нөхөн олговор | 288,582,700.00 | 227,873,655.00 |
| 210104 | Урамшуулал | 632,434,000.00 | 378,939,508.94 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 912,243,828.55 | 890,729,463.72 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 601,641,428.55 | 624,372,876.79 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 77,650,600.00 | 76,060,902.44 |
| 210203 | ҮОМШӨ ний даатгал | 38,825,300.00 | 40,204,430.65 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 38,825,300.00 | 33,808,246.12 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 155,301,200.00 | 116,283,007.72 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 1,069,909,000.00 | 924,026,922.00 |
| 210301 | Гэрэл цахилгаан | 214,282,000.00 | 124,129,472.50 |
| 210302 | Түлш, халаалт | 722,639,000.00 | 711,623,862.84 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 132,988,000.00 | 88,273,586.66 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 131,347,400.00 | 127,287,085.12 |
| 210401 | Бичиг хэрэг | 10,833,000.00 | 11,786,670.00 |
| 210402 | Тээвэр (шатахуун) | 75,614,600.00 | 72,233,314.12 |
| 210403 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 7,760,000.00 | 7,070,431.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 15,000,000.00 | 11,431,820.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | 22,139,800.00 | 24,764,850.00 |
| 2105 | Нормативт зардал | 1,772,939,500.00 | 1,616,965,777.61 |
| 210501 | Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,621,050,400.00 | 1,435,547,499.81 |
| 210502 | Хоол, хүнс | 143,889,100.00 | 173,628,277.80 |
| 210503 | Нормын хувцас зөөлөн эдлэл | 8,000,000.00 | 7,790,000.00 |
| 2106 | Эд хогшил худалдан авах | 90,685,700.00 | 74,137,389.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 10,620,000.00 | 7,612,250.00 |
| 210602 | Тавилга | 7,940,000.00 | 4,515,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | - | 1,970,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 72,125,700.00 | 60,040,139.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 11,938,300.00 | 11,893,280.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 11,938,300.00 | 11,893,280.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 52,508,600.00 | 46,011,225.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 12,824,700.00 | 11,703,275.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 2,280,000.00 | 2,280,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 5,000,000.00 | 5,000,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,000,000.00 | 688,532.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 209,000.00 | 209,000.00 |
| 210806 | Мэдээллийн технологийн зардал | 25,158,300.00 | 20,139,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,143,000.00 | 1,142,918.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 4,893,600.00 | 4,848,500.00 |
| 2201 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 10,736,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 10,736,000.00 |
| | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 449,041,600.00 | 532,055,696.57 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 449,041,600.00 | 371,276,156.57 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 331,335,600.00 | 306,640,156.57 |
| 213208 | Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж | 116,226,000.00 | 63,336,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 1,480,000.00 | 1,300,000.00 |
| 2133 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 160,779,540.00 |
| 213303 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | - | 160,779,540.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 11,921,916,528.55 | 11,248,991,165.31 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,129,909,000.00 | 1,129,909,000.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 1,129,909,000.00 | 1,129,909,000.00 |
| 1340 | НД-ЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 9,802,165,200.00 | 9,400,942,674.74 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 9,802,165,200.00 | 9,400,942,674.74 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 989,842,328.55 | 718,139,490.57 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 369,498,600.00 | 323,824,496.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 592,431,400.00 | 394,314,994.57 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 27,912,328.55 | - |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 44,824,149.55 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 17,772,385.40 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,471,887.6 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 25,526.4 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 2,446,361.2 мянган төгрөгийн 1 албан шаардлагыг хүргүүллээ.

***Залруулагдаагүй алдаа:***

Аудитаар нийт 2,471,887.6 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 1 төлбөрийн акт, 1 албан шаардлагыг тус тус хүргүүллээ.

### 3.1 Төлбөрийн акт

2025 оны 12-р сарын цалин бодохдоо эмч, сувилагч 130 хүнд илүү цагийн нэмэгдэл хөлсийг 2 хувиар тооцон 25,526.4 мянган төгрөгийг олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т (*жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх)*, 6.4.1-т (*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах)*, 6.4.8-д (*төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх)*, Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.1-т (*Илүү цагаар ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг нэг аравны тав дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж олгоно)*, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 9.15-д (*илүү цагаар ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг 1.7 дахин нэмэгдүүлж олгоно*) заасныг мөн үнэн зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь: Илүү тооцож олгосон нэмэгдлийг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.*

### 3.2 Албан шаардлага

Байгууллага, хувь хүмүүс, ажиллагсад, бараа үйлчилгээний зардалтай холбоотой 2,446,361.2 мянган төгрөгийн өглөг өссөн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т (*жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх)*, 6.4.1-т (*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*), 6.4-т (*төсвийг зохистой удирдаж, авлага, өглөг үүсгэхгүй байх*), 16 дугаар зүйлийн 16.5.5-д (*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах)* заасныг мөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна;

*Шийдвэрлэсэн нь:* Төсвийг зохистой удирдаж, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүллээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийцлийн аудиттай холбоотой 2,446,361.2 мянган төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь авч үзсэн, залруулагдах боломжгүй 25,526.4 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлаас 2.8 дахин бага  тул “ӨӨРЧЛӨЛТГҮЙ” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл:** /мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 2025 оны 12-р сарын цалин бодохдоо эмч, сувилагч 130 хүнд илүү цагийн нэмэгдэл хөлсийг 2 хувиар тооцон олгосон. | 1 | 25,526.4 | 1 | 25,526.4 | | | | | | |
| **Дүн** | **1** | **25,526.4** | **1** | **25,526.4** | | | | | **-** | **-** |

**4.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** /мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Тайлант хугацаанд байгууллага, хувь хүмүүс, ажиллагсад, бараа үйлчилгээний зардалтай холбоотой өглөг өссөн. | 1 | 2,446,361.2 | | | 1 | 2,446,361.2 | | | | |
| **Дүн** | **1** | **2,446,361.2** | | | **1** | **2,446,361.2** | | | | |